МОНГОЛ УЛС
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2017 оны 04 сарын 13 өдөр Дугаар А/113 Мандалговь

Шагнах тухай

Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 6 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дэлгэрхангай сумын уугуул "Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн төслийн инженер Г.Туяахүү Эрчим хүчний салбарын хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулж Монгол Улсын "Аж үйлдвэрийн гавъяат ажилтан" цол хүртсэн тул аймгийн Засаг даргын "Хүндэт өргөмжлөл", мөнгөн шагналаар шагнасугай.

Хоёр. Мөнгөн шагналд 500000 /таван зуун мянга/, хүндэт өргөмжлөл хэвлүүлэхэд 35000 /гучин таван мянга/, хадаг 5000 / таван мянга/, нийт 540000 /Таван зуун дөчин мянга/ төгрөгийг Аймгийн Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Тамгын газрын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ч.Даваа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

020000301